

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

**НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН 2024 ОНЫ 07 ДУГААР САРЫН 01-НИЙ ӨДРИЙН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ**

2024 оны 07 дугаар сарын 17

Улаанбаатар хот

Д/д	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Оноо
<b>Үүрэг, даалгавар ДӨРӨВ:</b> Хүнсний худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж буй иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж, хүнсний чанар, аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангуулах урьдчилан сэргийлж ажиллах.				
1	Монгол Улсын Зөвшөөрлийн тухай хуулийн 8 дугаар бүлгийн 8.2 дугаар зүйл (Энгийн зөвшөөрлийн жагсаалт)-ийн 10.13 дахь заалтад дүүргийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн гудамж, талбайд худалдаа, үйлчилгээ эрхлэх зорилгоор талбай ашиглах зөвшөөрлийг тухайн шатны Засаг дарга олгоно гэж заасны дагуу батлагдсан байршилд худалдаа үйлчилгээ эрхлэгч нь “Үйлчилгээ эрхлэх бүртгэлийн хуудас”-тай эсэх, орчны цэвэрлэгээ, стандартын шаардлага, мах махан бүтээгдэхүүний мал эмнэлгийн гэрчилгээний бичигтэй эсэхэд Нийслэлийн Удирдах ажилтны 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн шуурхай зөвлөгөөнөөс өгсөн чиглэлийн дагуу хяналт, шалгалт хийн илэрсэн зөрчлийг арилгуулахаар урьдчилан сэргийлж ажилласан. Дүүргийн 24 дүгээр хорооны нутаг Жигжидийн уулзвар болон Зунжин бүсэд үйл ажиллагаа явуулж буй нийт 35 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад Нийслэлийн Эрүүл мэндийн газрын Эрүүл мэндийн хяналтын хэлтэс, Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Нийслэлийн Мал эмнэлгийн газрын Эрүүл мэндийн хяналтын хэлтсийн мэргэжилтэн, дүүргийн Цагдаагийн 1, 2 дугаар хэлтсийн албан хаагч нар хяналт шалгалтыг хийн ажилласан.			100
<b>Үүрэг, даалгавар ТАВ:</b> Үер усны аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг сайтар зохион байгуулах				
2	Үер усны аюулаас сэргийлэх ажлын хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрийн 3 байршилд буюу 24 дүгээр хорооны Яргайтын богинод далан босгох, 4, 5 дугаар хороодод ус зайлуулах шугам хийх ажлыг 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрөөс 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрүүдэд тус тус хийж гүйцэтгэсэн.			100
<b>Үүрэг, даалгавар ЗУРГАА:</b> Өвөлжилтийн бэлтгэл ажлыг сайтар хангах.				

3	<p>Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд 45 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг байгуулан 11 салбарын 118 заалттай төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус ажлын хүрээнд 1650 тн бодис, 1750 тн давс тус тус нөөцөлж, цас орсон даруйд халтиргаа гулгаанаас урьдчилан сэргийлэх, халтиргаа гулгааг арилгах зорилгоор 100тн бодис, 130тн давс цацаж ажилласан бөгөөд 2024 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар нийт 1550тн бодис, 1620 тн давсны үлдэгдэлтэй байна.</p>			70
<b>ҮНЭЛГЭЭНИЙ ДУНДАЖ</b>				<b>90%</b>